

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРААС ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД
2023 ОНЫ ХАГАС ЖИЛД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт
Зорилт 1: Албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүрэг, хөдөлмөрийн гэрээнд заасан эрх, үүрэг, гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах ажлын байр, эрүүл ахуйн нөхцөл, бичиг хэргийн хэрэгсэл, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд нийцсэн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эд материал, ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, мэдээллээр хангах зорилтын хүрээнд:		
1	Ажлын байрны дотоод орчныг тохижуулах, эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх	Шинэ байранд орсонтой холбогдуулан Төгс хөшиг ХХК-аас 3.500.000 төгрөгийн туузан хөшиг авч, бүх өрөөг тохижуулсан. Цэвэрлэгээний материалд 1.555.700 төгрөг зарцуулсан.
2	Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, эд хогшил, техник хэрэгслээр хангах	Компьютер, тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэлд 611.900 төгрөг, Жуух бичиг, бичгийн цаас, принтерийн хор зэрэгт 4.623.500 төгрөг зарцуулсан. 6 сард 15 компьютер, 2 сервес, 2 хэвлэгч, бусад камер гэх мэт тоног төхөөрөмж худалдан авахаар бэлэн болоод байна. БОАЖЯ-аас фургон машин олгосон.
3	Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд шаардагдах мэдээллийг тогтмол шуурхай дамжуулах, тэднийг мэдээллээр хангах зорилгоор “Мэдээллийн самбар”, интернэт, дотоод сүлжээ, цахим хуудасны байнгын тасралтгүй ажиллагааг хангах	Интернет түгээх үйлчилгээнд 95.880.000 төгрөг, үүрэн телефонд 2.500.000 төгрөг, өндөр хурдны тоон сувгийн түрээсэнд 6.250.000 төгрөг, интернетийн сувагчлалын төлбөр 5.325.738 төгрөг, тоног төхөөрөмжийн түрээсэд 1.056.000 төгрөг зарцуулаад байна. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг сар бүр шинэчлэн мэдээллээр хангаж ажиллаж байна. Байгууллагын цахим сайт http://namem.gov.mn -д мэдээлэл байнга шинэчлэгдэн, мэдээллийг тогтмол шуурхай хүргэж байна.
Зорилт 2: Албан хаагчдыг хууль тогтоомжоор олгогдсон нийгмийн баталгаагаар бүрэн хангах, хөдөлмөрийн дотоод журамд заасан дэмжлэг, тусламж, тэтгэмжийг үзүүлэх зорилтын хүрээнд:		
1	Албан хаагчдын цалинг ажилласан жилийг харгалзан нэмэгдүүлэх, цол, эрдмийн зэрэг, мэргэшлийн зэрэг дэв, ур чадварын нэмэгдлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Засгийн газраас тогтоосон хувь хэмжээгээр олгох	Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын тогтоолын дагуу албан хаагчдын нэмэгдэл цалин хөлсийг олгож ажилласан. 2023 оны эхний 5 сарын байдлаар: -нийт албан хаагчдын 97% нь ажилласан жилийн нэмэгдэл сар бүр авсан бөгөөд сард дундажаар 8.5 сая төгрөг, -төрийн үйлчилгээний албан хаагчдын 93% нь ур чадварын нэмэгдэл сар бүр авсан бөгөөд сард дундажаар 5.1 сая төгрөг,

		- төрийн үйлчилгээний албан хаагчдын 23% нь мэргэшлийн зэргийн нэмэгдэл сар бүр авсан бөгөөд сард дундажаар 1.0 сая төгрөг, -төрийн захиргааны албан хаагчдын 50% нь зэрэг дэвийн нэмэгдэл авч байгаа бөгөөд сард дундажаар 3.4 сая төгрөг, -Докторын цолтой 3 албан хаагчид сард дундажаар 313 мянган төгрөг, - 15-18 албан хаагчдад ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл олгосон бөгөөд сард дундажаар 3.6 сая төгрөг, -Ээлжийн 16-18 ажилчдад шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг шөнийн цагт ажилласан хугацаанд олгосон бөгөөд сард дундажаар 1.7 сая төгрөг, -Илүү цагаар ажилласан 5 сарын нийт 41 албан хаагчдад 10,1 сая төгрөг олгосон байна.
2	Хоол, нийтийн тээврийн унааны зардлыг тухайн жилийн төсөвтэй уялдуулан нэмэгдүүлэх	Хоол, нийтийн тээврийн унааны зардал нийлээд 10.000 төгрөг байна.
3	Орон нутагт томилолтоор ажиллах албан томилолтын зардлыг олгох	Дотоодын томилолт байхгүй.
4	Албан хаагчдын ажлын бүтээмжийг шударга үнэлэх, ажлын байрны чиг үүргийг оновчтой тодорхойлох, ачааллыг жигдрүүлэх, үйл ажиллагааны үр дүнгээр шууд урамшуулах асуудлыг Засгийн газраас баталсан болон холбогдох бусад журмын дагуу явуулах	Хагас жилийн үнэлгээг хийж , үйл ажиллагааны үр дүнгээр шууд урамшуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөөд байна.
6	Төрийн албан хаагчийн ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх, ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй албан хаагчид ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгох	Эхний 5 сарын байдлаар 8 албан хаагч ээлжийн амралтыг биеэр эдлээд байна. Ээлжийн амралтад зориулж 5.9 сая төгрөгийг зарцуулаад байна.
7	Ээлжийн амралтаараа өөрийн, эсхүл эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутаг явах бол ирэх, очих замын зардлыг, эсхүл магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр дотоодын сувилалд сувилуулах бол ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож хоёр жилд нэг удаа олгох	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн "12.1.2.ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал;"-ыг санхүүжүүлэх, зарцуулахыг хориглосон.
8	Албан хаагчдын ажил үүргээ үр дүнтэй биелүүлж, амжилт гаргасан идэвх зүтгэлийг	Дэлхийн болон Монголын ус, цаг уурын өдрийг тохиолдуулан байгаль орчин, ус цаг уурын салбарт олон жил идэвхи зүтгэл гарган, үр бүтээл,

	үндэслэн төрийн дээд одон медаль, Засгийн газрын хүндэт өргөмжлөл, Төрийн албаны тэргүүний ажилтан, Байгаль орчны тэргүүний ажилтан, Хүндэт жуух бичиг болон бусад салбарын шагналд тодорхойлох, тус газрын шагналаар шагнах, мөнгөн шагнал, эд зүйл дурсгах	тогтвор суурьшилтай ажиллаж, ажилдаа амжилт гаргасан 51 албан хаагчийг Байгаль орчны тэргүүний ажилтан цол тэмдэгээр, 45 албан хаагчийг БОАЖЯ-ны "Жуух бичиг"-ээр, 128 албан хаагчдыг тус газрын "Жуух бичиг"-ээр тус тус шагнагдсан. Төрийн албаны тэргүүний ажилтан цол тэмдэгээр 2 албан хаагч шагнагдсан. Үүнээс тус газрын 1 албан хаагч Төрийн албаны тэргүүний ажилтан, 3 албан хаагч Байгаль орчны тэргүүний ажилтан цол тэмдэгээр, 5 албан хаагч тус газрын "Жуух бичиг"-ээр тус тус шагнагдсан.
9	Албан хаагчид Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу тусламж, дэмжлэг, тэтгэмж, нөхөн олговор олгох	Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн 2 албан хаагчид нийт 932.107 төгрөгийн нөхөн олговор олгосон.
10	"Эцэг эхийн зөвлөл"-ийг ажиллуулах, үйл ажиллагааг нь дэмжих	Тус газрын Эцэг, эхийн зөвлөл 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн газрын даргын А/175 дугаар тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Цаг уур, орчны шинжилгээний газрын албан хаагчдын хүүхдийн эрх, хамгааллын талаарх 2023 оны төлөвлөгөөг 9 арга хэмжээний хүрээнд зохион байгуулахаар газрын даргаар батлуулсан. Хүүхдийн өрөөг тус газраас гаргаж өгсөн хэдий ч Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу засвар, тохижилтын мөнгө байхгүй байгаа тул төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ 2023 оны хагас жилийн байдлаар байхгүй байна. Эцэг эхийн зөвлөл 2023 онд нэг удаа хуралдаж, тус байранд байрладаг байгууллагын удирдлагуудтай уулзаж хүүхдийн өрөө тохижуулах талаар зөвшилцсөн.
11	Албан үүргээ гүйцэтгэх явцад төрийн албан хаагчийн амь нас хохирсон тохиолдолд 60 сарын албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг түүний ар гэрт нь олгох	Ийм тохиолдол байхгүй.
Зорилт 3: Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, тэдэнд бие бялдар гоо зүйн төлөвшил олгох зорилтын хүрээнд:		
1	Эрүүл мэндээ хамгаалах, төрөл бүрийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн мэдээ, мэдээллийн булан цахим сайтад ажиллуулах	6 албан хаагч эмнэлэгт үзүүлэхээр өглөөний цагийн цалинтай чөлөө авсан. 3 албан хаагч эмчилгээ хийлгэж нийт 6 өдрийн цалинтай чөлөө авсан. 1 албан хаагчид гадаад урт хугацааны эмчилгээ хийлгэж байна. Чөлөө олгосон.

2	Албан хаагчдыг жилд 2-оос доошгүй удаа эрүүл агаарт аялуулах ажлыг зохион байгуулж, холбогдох зардлыг санхүүжүүлэх	2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр хамт олноороо цэвэр агаарт Цагаан-Өргөө амралтын газар вакумжсан орчинд маш үр дүнтэй сургалт, семинар зохион байгуулсан.
3	Албан хаагчдыг тус газрын спорт заал, бялдаржуулах өрөөнд спортоор хичээллэх нөхцөл боломжоор хангах, спортын арга хэмжээ зохион байгуулах	Тус газрын спорт заалыг тохижуулсан. Үүнд: хамгаалалтын тор, гар бөмбөг, сагсан бөмбөг, ширээний теннисний иж бүрдэл, шатар цагийн хамт 5 ширхэг. Албан хаагчид тус газрын спорт заал, бялдаржуулах өрөөнд спортоор хичээллэх нөхцөл бүрэн хангагдсан. -Дэлхийн болон Монголын ус, цаг уурын өдрийг тохиолдуулан албан хаагчдын дунд 3 дугаар сарын 31-ээс 2 өдөр гар бөмбөг, сагсан бөмбөг, ширээний теннис, дартс, шатар гэсэн 5 төрөлт тэмцээн, -1 дүгээр сарын 19-ны өдөр харьяа байгууллагын удирдах ажилтны семинарыг тохиолдуулан сагсан бөмбөг, ширээний теннис, -Орчны шинжилгээний хэлтсийн хамт олон ширээний теннис, сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээнийг хэлтэс дотроо зохион байгуулсан. -3 сарын 1-ээс 1 сарын хугацаатай бачата бүжгийн сургалт зохион байгуулсан.

ХЯНАСАН: ЗАХИРГАА, АУДИТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Н.ГАЛЦОГ

ТАЙЛАНГ БИЧСЭН: ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ж.ЭНХЧИМЭГ

